



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 114


Улаанбаатар хот

Хорооны орон тооны бус гишүүнд олгох  
урамшууллын хэмжээг шинэчлэн  
тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм,-ийн 2.2.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хорооны орон тооны бус гишүүнд урамшуулал олгох журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

Нэг. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд сар бүр олгох урамшууллын хэмжээг 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 500.000 төгрөгөөр тогтоосугай.

Хоёр. Орон тооны бус гишүүнд олгохоор тогтоосон урамшууллыг Хорооны төсвийн холбогдох зардлаас олгохыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН